



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ХУВЬЦАА**  
**ЭЗЭМШИГЧДИЙН**  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
МАТЕРИАЛ

---

2018.04.17



# АГУУЛГА

- 04 ● Мэндчилгээ
- 04 ● Хурлаар хэлэлцэх асуудал
- 05 ● Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
- 06 ● Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа
- 07 ● Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой төсөл
  1. Говь ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт
  2. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төсөл
  3. 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай
  4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид
  5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох санал
- 18 ● Хурлаас гарах тогтоолын төсөл
- 22 ● Саналын хуудасны загвар

## МЭНДЧИЛГЭЭ

### ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ!

Бид өнгөрөгч 2017 онд бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн бүтээмжээ нэмэгдүүлэн дотооддоо болон дэлхийн зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ таниулж зах зээлээ өргөтгөн амжилттай ажиллалаа. Өдгөө та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг нэгтгэн хүргэж байна.

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 сарын 17-ны өдрийн 14:00 цагт Хан-уул дүүргийн 3-р хороо, Говь ХК-ийн төв дэлгүүрийн дэргэдэх "Мираж" гэр ресторанд болно.

### ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. ТУЗ-өөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай хэлэлцэн батлах
3. 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
4. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг батлах
5. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай хэлэлцэн батлах

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс энэхүү номтой танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер дилерийн компанидаа эсвэл "Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК" хаягаар 2018 оны 4 сарын 13-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх  
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 3 минут
2. Тооллогын комисс болон редакцын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах  
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут
3. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:
  - 3.1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах  
/Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Сүрэнрагчаа/ 10 минут
  - 3.2. ТУЗ-өөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах  
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 10 минут
  - 3.3. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн тухай дүрмийн төслийг танилцуулах  
/Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр/ 3 минут
  - 3.4. 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах  
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут
  - 3.5. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга  
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут
  - 3.6. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай танилцуулах  
/ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны дарга Д.Гэрэлмаа/ 5 минут
4. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт Хүн тус бүр 3 минут
5. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, шүүмжлэл: Хүн тус бүр 3 минут
6. Саналын хуудсаар санал авах 10 минут
7. Бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга 20 минут
  - Загварын шоуны бичлэг, шинэ бүтээгдэхүүний танилцуулга
  - Үдийн цай
8. Санал хураалтын дүнг нэгтгэн, тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах 5 минут
9. Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал асуулгын дүнг тусган редакцын комиссын дарга танилцуулж төслийг батлуулах 5 минут

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.

### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

## ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2018 оны 3 сарын 16-ны өдрөөс эхлэн 4 сарын 13-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж танилцаж болно.

Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

1. Компанийн санхүүгийн жилийн тайлан
2. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт
3. Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт
4. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
5. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал
6. Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл

## 1. ГОВЬ ХК-ИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.ГЭРЭЛМАА

Говь ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2017 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2017 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь түүхий эд бэлтгэлийн ажлыг сайтар зохион байгуулах, гадаад дотоод захиалгыг үйлдвэрлэлтэй нягт хослуулан, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахад чиглэсэн билээ.

Говь ХК 2017 онд 124.4 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж бизнес төлөвлөгөөний биелэлт 113%, цэвэр ашиг 17.5 тэрбум төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөө 97%-ийн гүйцэтгэлтэй гарлаа. Говь ХК-ийн гадаад борлуулалт 2017 онд 49.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 44% өсч, 74.6 тэрбум төгрөгийн дотоод борлуулалт хийж өмнөх оноос 38%-ийн өсөлтийг тус тус хангасан байна.

Мөн 2017 онд түүхий эд бэлтгэлийг өмнөх 2016 оноос 54%-иар нэмэгдүүлж, нийт 743 тонн түүхий эд бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нийт 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 7.4 тэрбум төгрөг буюу 69%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 3.3 тэрбум төгрөг буюу 31%-ийг барилгын өргөтгөл, шинэчлэлт болон бусад хөрөнгө оруулалтад зориулсан байна.

Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2017 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

### ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## 2. КОМПАНИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

№	Одоогийн дүрмийн заалт	Шинэчилсэн заалт
6.2 Төлөөлөн Удирдах Зөвлөл		
1	6.2.2 ТУЗ нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна.	6.2.2 ТУЗ нь <b>9 буюу түүнээс дээш</b> гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна.
2	6.2.7.11 ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлах;	6.2.7.11 ТУЗ, <b>гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;</b>
6.3 Гүйцэтгэх удирдлага		
3	6.3.3.4 Компанийн дотоод журмыг баталж, мөрдүүлэх;	6.3.3.4 Компанийн дотоод журам, <b>үйл ажиллагааны дүрэм, журам, зааврыг</b> баталж, мөрдүүлэх;
4	6.3.3.6 Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулах;	6.3.3.6 <b>ТУЗ-өөс олгосон эрх мэдлийн хүрээнд</b> компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй <b>шууд</b> харилцаж, <b>тэдэнтэй</b> гэрээ, хэлэлцээр байгуулах;
5	6.3.3.9 Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. Өөрийн ажлын аппаратыг байгуулж, түүний бүтэц, төсвийг ТУЗ-өөр батлуулан үйл ажиллагаа явуулах;	6.3.3.9 Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. <b>ТУЗ-өөс баталсан төсвийн хүрээнд компанийн бүтэц, орон тоог бие даан баталж мөрдүүлэх;</b>
6	6.3.3.8 Компанийн бүтээгдэхүүний дотоодод мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх;	6.3.3.8 Компанийн бүтээгдэхүүний дотоод болон <b>гадаад орнуудад</b> мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх;

Жич: Компанийн одоогийн дүрмийг 2016 оны 9 сарын 19-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар баталсан болно.

## 3. 2016 ОНЫ НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН, 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ТАРААХ ТУХАЙ

### 2016 ОНЫ НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	Нийт хувьцааны тоо (шир)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (төг)	Ногдол ашиг олгосон хэлбэр	Олгосон ногдол ашиг (төг)	Олгосон ногдол ашиг (%)	Хувьцааны тоо (шир)	Хувьцаа эзэмшигчийн тоо
2016	200	7,801,125	1,560,225,000	Компани дээр	1,396,956,200	89.5%	6,984,781	320
				ҮЦТХТ-өөр зуучлуулан	163,268,800	10.5%	816,344	15,850
Нийт					1,560,225,000	100%	7,801,125	16,170

2016 онд зарласан ногдол ашгийг 2017 оны 4 сарын 20-ны өдрөөс компани дээрээ тарааж эхэлсэн ба хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгож нийт зарласан ногдол ашгийн 89.5%-ийг компани дээрээ олгосон.

2017 оны 12 сарын 26-ны өдөр ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган, нийт 15,850 хувьцаа эзэмшигчийн 816,344 ширхэг хувьцаанд ногдох 163,268,800 төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд нь шилжүүлэх замаар 100% тараасан.

### 2017 ОНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарын чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг өсгөж, ногдол ашиг тогтмол тараахыг зорьдог.

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 2 сарын 2-ны өдрийн хурлын №4 тогтоолоор 2017 оны санхүүгийн үр дүнгээс хувьцааны нэгж тутамд 220 төгрөг буюу нийт 1,716,247,500 төгрөгийг ногдол ашигт тараахаар шийдвэрлэсэн. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ 10% өссөн үзүүлэлттэй байна.

### 2017 ОНЫ НОГДОЛ АШГИЙГ ТАРААХ АРГА ХЭЛБЭР

2017 оны ногдол ашгийг 2018 оны 4 сарын 24-ний өдрөөс эхлэн компани дээрээ тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох бөгөөд 2018 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд нь шилжүүлэх болно.

#### 4. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

##### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД:

1. Мягмарын БАЯР
2. Дамбын ГЭРЭЛМАА
3. Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ
4. Такэши КАМБЭ нарыг улируулан сонгох
5. Зуунайн ШАГДАРСУРЭН-г шинээр сонгох

##### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД:

6. Цагаачийн БААТАРСАЙХАН
7. Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ
8. Хидэо САВАДА
9. Дашдаваагийн ХУЛАН нарыг улируулан сонгохоор нэр дэвшүүлж байна.

#### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ НАМТАР



##### МЯГМАРЫН БАЯР

###### МЭРГЭЖИЛ

Оёдлын үйлдвэрийн технологич инженер

###### БОЛОВСРОЛ

1992-1996 Монгол улс, Техникийн Их Сургууль, Оёдлын үйлдвэрийн технологич инженер, бакалавр  
1996-1997 Монгол улс, Техникийн Их Сургууль, Оёдлын үйлдвэрийн технологич инженер, магистр  
2002-2006 Франц улс, ENSISA, Инженерийн шинжлэх ухаан, доктор  
2010-2011 БНСУ, Конкук Их Сургууль, Хувцас үйлдвэрлэлийн шинэ технологи (Digital fashion), пост-доктор

###### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1997-2001 ШУТИС-ийн ҮТДС-ийн Оёдлын тэнхимд багш  
2001-2007 ШУТИС-ийн Хувцас Судлал, Дизайны профессорын багийн Ахлах багш  
2007-2011 ШУТИС-ийн Хувцас Судлал, Дизайны профессорын багийн дэд профессор  
2011-2014 ШУТИС-ийн Хувцас Судлал, Дизайны профессорын багийн тэргүүлэх профессор  
2014 оноос ШУТИС-ийн ҮТС-ийн Нэхмэл судлалын салбарын дэд профессор, Хувцас судлалын төвийн захирал  
2016 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



##### ДАМБЫН ГЭРЭЛМАА

###### МЭРГЭЖИЛ

Эдийн засагч

###### БОЛОВСРОЛ

1982-1988 ЗХУ, Москва хотын Цахилгаан холбооны дээд сургууль, Холбооны инженер эдийн засагч, бакалавр  
2000-2003 МУ-ын ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг “Удирдлагын академи”, Удирдахуйн ухааны доктор

###### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1988-1992 Радио Телевизийн Техникийн Төв эдийн засагч  
1992-1994 Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, багш  
1994-2003 Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, тэнхимийн эрхлэгч  
2003-2006 Монгол Улсаас НҮБ-д суух Байнгын төлөөлөгчийн газар, Швейцарийн Холбооны улс дахь ЭСЯ, нягтлан бодогч  
2006-2009 СЭЗИС, Сургалт Эрдэм Шинжилгээ эрхэлсэн дэд захирал  
2009-2015 СЭЗИС, Сургалт эрхэлсэн дэд захирал  
2015 оноос СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор  
2013 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



## БАНЗРАГЧИЙН НАНДИН-ЭРДЭНЭ

**МЭРГЭЖИЛ**  
Эдийн засагч

### БОЛОВСРОЛ

1999-2003 Монгол улс, СЭЗДС, Бизнесийн Удирдлага, бакалавр  
2003-2005 Монгол улс, СЭЗДС, Бизнесийн Удирдлага, магистр  
2010-2012 Австралийн Үндэсний Их Сургууль, Маркетингийн Удирдлага, магистр

### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2003-2009 СЭЗИС-ийн Бизнесийн Удирдлагын тэнхимийн багш, ахлах багш  
2009-2010 СЭЗИС-ийн Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн эрхлэгч  
2013-2015 СЭЗИС-ийн Бизнесийн Удирдлагын тэнхимийн эрхлэгч  
2013-2015 Монголын Үндэсний Маркетингийн Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн  
2012-2014 МУИС НСС хөтөлбөр, Зочин багш  
2012-2016 Монгол лектор төв, CEO коллеж хөтөлбөр, Зочин багш  
2015 оноос СЭЗИС-ийн Бизнесийн Удирдлагын тэнхим, Ахлах багш  
2015 оноос Аксиом Инк ХХК, Захирал  
2016 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



## ЗУУНАЙН ШАГДАРСҮРЭН

**МЭРГЭЖИЛ**  
Хуульч, Эрх зүйч

### БОЛОВСРОЛ

1997-2001 Япон улс, Токиогийн их сургууль, Эрх зүйч, бакалавр  
2001-2003 Япон улс, Токиогийн их сургууль, Эрх зүйч, магистр  
2005-2006 Америкийн нэгдсэн улс, Мичиганы их сургууль, Эрх зүйч, магистр

### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2003-2005 Монгол банк, Хуулийн хэлтэс, Хуульч  
2006-2008 Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Эрх зүйн газар, Хуульч  
2009-2012 Монголын банкны холбоо, Гүйцэтгэх захирал  
2012 оноос Бие даан өмгөөлөгч, зөвлөх  
2017 оны 12 сараас Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр түр томилогдсон.



## ТАКЭШИ КАМБЭ

**МЭРГЭЖИЛ**  
Эдийн засагч

### БОЛОВСРОЛ

1978-1981 Япон улс, Кэйогийн Их Сургууль, эдийн засгийн ухааны бакалавр  
1981-1985 Япон улс, Кэйогийн Их Сургууль, эдийн засгийн ухааны магистр

### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1985-1986 Япон улс, Asahi Mutual Life Insurance компани, хүний нөөцийн менежер  
1986-1988 Нагано салбарын захиргааны менежер  
1988-1989 Киото салбарын худалдааны менежер  
1989-1992 Японы хамтын ажиллагааны банкны Гадаадын хамтын ажиллагааны эдийн засгийн фондын зээлийн мэргэжилтэн, Азийн хөгжлийн банк болон Дэлхийн Банкны хамтран хэрэгжүүлсэн Бангладеш улсад хэрэгжүүлсэн Жамнагийн олон зорилтот гүүрийн төсөл, Шриланк улсад хэрэгжүүлсэн Их Коломбийн харилцаа холбоог боловсронгуй болгох төсөл, Мянмариин Олон улсын харилцаа холбооны шугамыг шинэчлэх төсөлд тус тус ажиллаж байсан.  
1992-1995 Азийн даатгалын компанийн Олон улсын хөрөнгө оруулалтын газрын хөрөнгө оруулалтын санхүүжилт зээлийн менежер  
1995-1998 Гонгконг дахь азийн хөрөнгө оруулалтын удирдагч  
1998-1999 АНУ-ын даатгалын хамтын ажиллагааны бүртгэлийн ухааны сургалтад хамрагдсан  
1999-2000 Азийн даатгалын хамтарсан компанийн Удирдлагын зөвлөлийн дарга  
2000-2002 Азийн үл хөдлөх хөрөнгө ХХК-ийн зээлийн болон судалгаа шинжилгээний менежер  
2001-2003 Номхон далайг хамгаалах нийгэмлэгийн гишүүнээр сонгогдсон  
2002-2006 Азийн даатгалын хамтарсан компанийн жижиг дунд корпорацуудад арилжааны зээл олгох асуудлыг хариуцсан менежер  
2006 оноос Азийн даатгалын хамтарсан компанийн үл хөдлөх хөрөнгийн арилжааны хяналтын менежер  
2008 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



## ЦАГААЧИЙН БААТАРСАЙХАН

**МЭРГЭЖИЛ**  
Электроникийн инженер

**БОЛОВСРОЛ**  
1984-1988 Монгол улс, Политехникийн их сургууль, Холбооны инженер, бакалавр  
1988-1989 Япон улс, Токиогийн гадаад хэл судлалын япон хэлний анги  
1989-1993 Япон улс, Токио хотын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургууль, Электроникийн инженер, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**  
1993-1997 Япон Монголын хамтарсан "Алтай" компанид Орлогч захирал  
1997-1999 Таван Богд компанийн ерөнхий захирал, Таван Богд Трейд ХХК-ийн ерөнхий захирал  
1999-2000 Жуулчин ХХК-ийн ерөнхий захирал  
2000-2001 Палас зочид буудлын Гүйцэтгэх захирал  
2001-2003 МИАТ компанийн ерөнхий захирал  
2003 оноос Таван Богд Группийн ерөнхийлөгч, Палас болон Хаан Палас зочид буудлын ТУЗ-ийн дарга  
2007 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  
2008 оноос Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал



## ЖАВЗАНДОЛГОРЫН ОЮУНЧИМЭГ

**МЭРГЭЖИЛ**  
Сэтгүүлч

**БОЛОВСРОЛ**  
1995-1996 Монгол улс, "Шавь" сэтгүүл зүйн дээд сургууль, сэтгүүлч  
1993-1997 МУИС, Монгол судлалын сургууль, Судлаач багш, бакалавр  
1996-1998 МУИС, Монгол судлалын сургууль, Сэтгүүлч, магистр  
2009-2011 Удирдлагын академи, Бизнесийн удирдлага, магистр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**  
1998-1999 Монголньос Өнөөдөр сонин, Сэтгүүлч  
1999-2007 Монгол ньос ХХК-ийн дэргэдэх Оюуны Өргөө Дээд Сургууль, Гүйцэтгэх захирал, Сургалтын албаны дарга  
2008-2009 УИХ-ын тамгын газар, УИХ-ын гишүүний ажлын алба  
2007 оноос Таван Богд Групп, Маркетингийн хэлтсийн дарга  
2016 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



## ХИДЭО САВАДА

**МЭРГЭЖИЛ**  
Эдийн засагч

**БОЛОВСРОЛ**  
1973-1976 Герман улс, Майнзын Их Сургууль, Эдийн засагч, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**  
1980-1996 Интернейшнл түүрс компанийн үүсгэн байгуулагч, захирал  
1996-1999 Австралийн Алтан Ирэг дээрх Вотээмак зочид буудлын эзэн, "Скаймаак эйрлайн" компанийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга  
1999-2001 "Эйч Ай Эс кёрицу" үнэт цаасны компанийн Ерөнхийлөгч  
2000 онд Токиогийн Хөрөнгийн биржийн толгой компани "Смаймак" үнэт цаасны ХХК-ийн Ерөнхийлөгч  
2002 онд Токиогийн Хөрөнгийн биржийн толгой компани "Эйч Ай Эс" үнэт цаасны компанийн Ерөнхийлөгч  
2003 онд Хаан банкны ТУЗ-ийн дарга  
2004 оноос Токиогийн хөрөнгийн биржийн "Эйч Ай Эс" үнэт цаасны ХХК-ийн болон Осака хотын хөрөнгийн биржийн "Эйч Эс" үнэт цаасны ХХК-ийн Ерөнхийлөгч  
2009 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



## ДАШДАВААГИЙН ХУЛАН

**МЭРГЭЖИЛ**  
Эдийн засагч

**БОЛОВСРОЛ**  
1985-1990 Орос улс, Москвагийн Санхүүгийн Дээд сургууль, Олон улсын эдийн засагч, бакалавр  
1992-1993 Монгол улс, Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн удирдлага, магистр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**  
1990-1992 Монгол Улсын Сангийн Яам, Гадаад харилцааны хэлтэс, Эдийн засагч  
1993-1997 Говь корпораци, Токио дахь салбар, Борлуулалтын менежер  
1997-2000 Таван Богд Трейд ХХК, Тэргүүн дэд захирал  
2000-2002 Худалдаа Хөгжлийн Банк, Дэд захирал  
2000-2002 Кредит Монгол зээлийн хорооны гишүүн  
2003 оноос Таван Богд Групп, Тэргүүн дэд ерөнхийлөгч  
2003 оноос Хаан Банкны ТУЗ-ийн гишүүн  
2008 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  
2009 оноос Люксембургийн Монгол улс дахь өргөмжит консул  
2013 оноос Таванбогд Фүүдс ХХК, Гүйцэтгэх захирал  
2014 оноос Таванбогд Фүүдс Пицца ХХК, Гүйцэтгэх захирал



5. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ САНАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалин		Одоогийн /төг/	Шинэчлэх санал /төг/	Өсөлт /хувь/
Тогтмол цалин	Үндсэн	500,000	1,000,000	100%
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	400,000	800,000	100%
	Хорооны даргын нэмэгдэл	150,000	300,000	100%
Оролцоонд үндэслэсэн цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	500,000	500,000	0%
Сарын дундаж цалин	ТУЗ-ийн гишүүд	928,000	1,520,000	64%
	Нийт /9 гишүүний/	8,350,000	13,700,000	64%

Жич: Одоогийн цалин урамшууллын хэмжээг 2013 оны 4 сарын 18-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар тогтоосон болно.

ТУЗ-ийн гишүүд доорх хурлуудад биечлэн сууж, оролцсон тоонд үндэслэн оролцооны цалинг тооцон улиралд нэг удаа олгодог.

Хурлууд	Хурлын тоо
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Жилд 1 удаа
ТУЗ-ийн ээлжит хурал	Жилд 6 удаа
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурал	Жилд 4 удаа
ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурал	Жилд 2 удаа
ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны ээлжит хурал	Жилд 2 удаа

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Төсөл

### ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 сарын 17-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

#### *Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2018 оны 4 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**

Төсөл

### ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 сарын 17-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

#### *Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.1 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2018 оны 4 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

**Хоёр.** Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдсүгэй.

**ХУРЛЫН ДАРГА**

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 сарын 17-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг батлах тухай*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалтууд, Компанийн дүрмийн 6.1.9.8, 6.2.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2018 оны 4 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

**Хоёр.** Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Мягмарын БАЯР

Дамбын ГЭРЭЛМАА

Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ

Такэши КАМБЭ

Зуунай ШАГДАРСҮРЭН нарыг;

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

Цагаачийн БААТАРСАЙХАН

Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ

Хидэо САВАДА

Дашдаваагийн ХУЛАН нарыг тус тус 3 жилийн хугацаагаар сонгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 сарын 17-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

*ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын  
хэмжээг шинэчлэн тогтоох тухай*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6.1.9.12 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зүгээс оруулсан санал болон 2018 оны 4 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалинг тогтмол цалин болон гишүүдийн оролцоонд үндэслэсэн оролцооны цалингаас бүрдэхээр тогтоосугай.

**Хоёр.** ТУЗ-ийн гишүүдийн тогтмол цалин болон оролцооны цалингийн хэмжээг Хавсралт 1 ёсоор шинэчлэн тогтоосугай.

**Гурав.** ТУЗ-ийн гишүүдийн тогтмол цалинг сар бүр, оролцооны цалинг Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоонд үндэслэн тооцож, улиралд нэг удаа олгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ**  
**ХУУДАС**

*Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 сарын 17-ны өдрийн 14:00 цагт Говь ХК-ийн дэргэдэх “Мираж” гэр ресторанд хуралдана.*

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр .....  
 Эзэмшиж буй хувьцааны тоо ..... төрөл ..... *энгийн* .....  
 Дансны дугаар ..... Регистрийн дугаар .....

Батлах асуудлууд:	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
-------------------	------------	------------	------------

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах /Саналыг энгийн аргаар тоолно./

*Дүгнэлт: Өөрсдийн нооц бололцоог бүрэн дүүрэн ашиглан ажигласан*

2. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах /Саналыг энгийн аргаар тоолно./

*Санал: Өөрчлөлтийг оруулъя*

3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг батламжлах /Саналыг кумулятив аргаар тоолно./

Санал: ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгоё	Нэр дэвшигчид өгөх кумулятив саналын тоо
1. Мягмарын БАЯР	<input type="text"/>
2. Дамбын ГЭРЭЛМАА	<input type="text"/>
3. Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ	<input type="text"/>
4. Такэши КАМБЭ	<input type="text"/>
5. Зуунай ШАГДАРСҮРЭН	<input type="text"/>

Санал: ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгоё	Нэр дэвшигчид өгөх кумулятив саналын тоо
1. Цагаачийн БААТАРСАЙХАН	<input type="text"/>
2. Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ	<input type="text"/>
3. Хилэо САВАДА	<input type="text"/>
4. Дашдаваагийн ХУЛАН	<input type="text"/>

4. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэх /Саналыг энгийн аргаар тоолно./

*Санал: Цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтооё*

2018 оны ... -р сарын ... -ны өдөр

Гарын үсэг .....



*“Говь” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны ... сарын ...-ны өдрийн хурлын ...-р тогтоолын ... дүгээр хавсралт*

**САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ**

1. Саналын хуудсыг дараах зааварын дагуу бөглөнө.

- Саналыг энгийн аргаар тоолох асуудлын хувьд саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (✓) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (✓), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (✓), түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина.
- Засварласан, балласан, (✓)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар санал хураах бөгөөд хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох 5, ердийн гишүүнийг сонгох 4 саналын эрх байна. Энэхүү саналын эрхээ хараат бус болон ердийн нэг нэр дэвшигчид бүгдийг нь эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх боломжтой.

2. Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцдаг брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК хаягаар 2018 оны 4 сарын 13-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

3. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх хүний:

Овог ..... нэр .....

Таны:

Овог ..... нэр .....

Утасны дугаар .....

Гарын үсэг .....



**GOBI**

MONGOLIAN CASHMERE

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081  
И-мэйл: [info@gobi.mn](mailto:info@gobi.mn)